



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/83/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.com</p> <p>Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261885 Цахим хаяг: tsogbayar.a@audit.com</p> <p>Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 261740 Цахим хаяг: bujinkhand.j@audit.com</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: "Грант торнтон аудит" ХХК-ийн захирал: О.Идшинринжин Утас: 70110799 Цахим хаяг: info@mn.gt.com</p>
-----------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Албан шаардлага.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗҮЧБ	Замын-Үүд чөлөөт бүс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭЗХАБ	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.03 № 06/932
танай _____-ны № _____-г

ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БҮС ХӨГЖҮҮЛЭХ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ З.БОЛДБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх нь төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2,860,819.5 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- “Замын-Үүд чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах” ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлын төлбөр 2,360,437.5 мянган төгрөгийг олгохдоо санхүүгийн тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй, зардлаар тайлагнасан.
- Сангийн сайдын 2024 оны 01/10803 тоот тушаалаар гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн зөвлөх үйлчилгээний зардлыг зогсоох шийдвэр гарснаас хойш “Замын-Үүд чөлөөт бүсийн тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих” ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжид 389,540.4 мянган төгрөгийг шилжүүлсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1, Сангийн сайдын 2025

оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 21.4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын" 1, 2.1-2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "оршин байх", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл нь Азийн Хөгжлийн Банкны 30,000 мянган ам.долларын зээлийн санхүүжилтийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд худалдааны чөлөөт бүсэд 900 га талбайд дэд бүтцийн ажил буюу 4 эгнээтэй шинэ гол зам, 2 эгнээтэй туслах шинэ замыг явган хүний зам, гэрэлтүүлэг; дулаан, цэвэр усан хангамж, бохир болон саарал усны шугам сүлжээ, цахилгаан дамжуулах шугам сүлжээ, мэдээлэл холбооны шугам сүлжээ зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх компаниудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан ба гүйцэтгэгч компаниуд 2025 оны 11 сараас өөрийн эх үүсвэрээр дэд бүтцийн ажлыг хийж эхлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрийн 30,000 мянган ам.долларын зээлээс дэд бүтцийн барилгын ажил, бараа нийлүүлэх, зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд 2,420 мянган ам.доллар, санхүүжилтийн шимтгэлд 80 мянган ам.долларыг зарцуулж, 27,500 мянган ам.долларын зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Бусад асуудал

Төслийн хэрэгжих хугацаа 2025 онд дууссан ба Азийн Хөгжлийн Банкнаас 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр 24 сараар буюу 2028 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,185,216,162.73	963,140,224.85
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	1,097,412,931.76	875,548,695.39
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,097,412,931.76	875,548,695.39
3121	Төрийн сангийн харилцах	11,907,428.34	14,816,097.79
31221	Төрийн сангийн харилцах	1,085,505,503.42	860,732,597.60
33500	Бусад авлага	84,833,230.97	84,621,529.46
34	УРЬДЧИЛГАА	2,970,000.00	2,970,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,970,000.00	2,970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	229,489,220.64	1,806,488,353.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	229,489,220.64	191,525,134.32
39200	Биет хөрөнгө	228,322,553.84	191,525,134.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	170,000,000.00	170,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,000,000.04)	(34,000,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	75,519,497.50	75,519,497.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,296,996.73)	(56,649,536.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,448,799.70	19,448,799.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,807,079.86)	(8,751,959.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,000,000.00	35,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,541,666.73)	(9,041,666.77)
393	Биет бус хөрөнгө	1,166,666.80	466,666.84
39301	Программ хангамж	3,500,000.00	3,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,333,333.20)	(3,033,333.16)
39400	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	1,614,496,552.36
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,414,705,383.37	2,769,628,578.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,352,292,550.66	85,005,826.88
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,352,292,550.66	85,005,826.88
413	Өглөг	1,352,292,550.66	85,005,826.88
41361	Байгууллагад төлөх өглөг	1,352,168,550.66	85,005,826.88
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	124,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	62,412,832.71	2,684,622,751.49
51	Засгийн газрын хувь оролцоо	62,412,832.71	2,684,622,751.49
512	Хуримтлагдсан үр дүн	62,412,832.71	2,684,622,751.49
51210	Өмнөх үеийн үр дүн	528,823,854.77	910,746,040.47
51220	Тайлант үеийн үр дүн	(466,411,022.06)	1,773,876,711.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,414,705,383.37	2,769,628,578.37

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	3,233,282,376.12	3,957,904,056.75
12	Татварын бус орлого	3,233,282,376.12	3,957,904,056.75
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,233,282,376.12	3,957,904,056.75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,222,981.81	-
141001	Гадаадын санхүүгийн зах зээлийн эх үүсвэр	3,216,860,517.31	3,945,404,056.75
335113	Бусад орлого	198,877.00	12,500,000.00
2	Үйл ажиллагааны зардлын дүн (II)	3,708,724,523.07	2,222,414,723.74
21	Урсгал зардал	3,708,724,523.07	2,222,414,723.74
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	3,708,724,523.07	2,222,414,723.74
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	309,235,695.94	298,808,299.10
210101	Үндсэн цалин	309,235,695.94	298,808,299.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,815,156.32	50,386,610.15
210201	Тэтгэврийн даатгал	26,244,330.67	35,637,843.04
210202	Тэтгэмжийн даатгал	3,261,530.91	5,389,012.90
210203	ҮОМШ-ний даатгал	2,087,530.91	2,783,301.44
210204	Ажилгүйдлийн даатгал	474,728.82	743,211.17
210205	Эрүүл мэндийн даатгал	4,747,281.82	5,833,241.60
2103	Байр ашиглалтын холбоотой тогтмол зардал	35,640,000.00	53,460,000.00
210304	Байрны түрээс	35,640,000.00	53,460,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,855,214.21	12,593,676.68
210401	Бичиг хэрэг	3,505,200.00	3,651,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,156,472.00	5,328,177.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,793,561.21	3,614,499.68
210404	Ном, хэвлэл	336,400.00	-
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,063,581.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361,300.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	361,300.00	-
2107	Томилолт, зочны зардал	14,216,989.00	9,618,300.00
210604	Дотоод албан томилолт	14,216,989.00	9,618,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,246,656,804.12	1,740,265,252.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,240,500,902.13	1,724,168,647.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	12,063,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,888,740.00	2,910,124.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,010.00	543,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,462,814.00	400,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	596,337.99	179,251.00
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	51,943,363.48	57,282,585.48
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	14,445,944.00	19,785,166.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	37,497,419.48	37,497,419.48
3	Үйл ажиллагааны үр дүн	(475,442,146.95)	1,735,489,333.01
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн	9,031,124.88	49,223,857.43
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	9,031,124.88	49,223,857.43
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	-	(10,836,479.42)
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	(10,836,479.42)
4	Үйл ажиллагааны бус үр дүн	9,031,124.88	38,387,378.01
5	Нийт үр дүн	(466,411,022.08)	1,773,876,711.02

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,216,860,517.31	3,957,904,056.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,216,860,517.31	3,957,904,056.75
120	Нийтлэг татварын бус орлого	-	12,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	12,500,000.00
122	Тусламжийн орлого	3,216,860,517.31	3,945,404,056.75
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,216,860,517.31	3,945,404,056.75
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,445,860,433.72	3,851,187,035.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,445,860,433.72	3,851,187,035.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,445,860,433.72	3,851,187,035.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,994,532.74	309,979,865.29
210101	Үндсэн цалин	315,994,532.74	309,979,865.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,700,515.41	39,283,294.45
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	38,700,515.41	39,283,294.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,550,000.00	53,460,000.00
210304	Байрны түрээс	44,550,000.00	53,460,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,690,342.21	12,334,499.68
210401	Бичиг хэрэг	3,505,200.00	3,590,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,991,600.00	5,129,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,793,561.21	3,614,499.68
210404	Ном, хэвлэл	336,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,063,581.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,045,663.64	1,400,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	8,045,663.64	1,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,381,861.00	11,635,200.00
210702	Дотоод албан томилолт	15,381,861.00	11,635,200.00
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,996,531,774.72	3,407,340,684.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	1,989,895,672.73	3,391,026,079.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	12,063,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,888,740.00	2,910,124.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,010.00	543,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,943,014.00	618,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	596,337.99	179,251.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,965,744.00	15,753,491.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,965,744.00	15,753,491.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	771,000,083.59	106,717,021.62
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	154,545,454.55	366,968,636.00
223001	Бусад хөрөнгө	154,545,454.55	366,968,636.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(154,545,454.55)	(366,968,636.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	8,525,431.58	49,223,857.43
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	(10,836,479.42)
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	624,980,060.62	(221,864,236.37)

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

10	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	472,432,871.14	1,097,412,931.76
11	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,097,412,931.75	875,548,695.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	528,823,854.77	528,823,854.77
2	Тайлант үеийн үр дүн	-	(466,411,022.06)	(466,411,022.06)
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	62,412,832.71	62,412,832.71
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	848,333,207.76	848,333,207.76
5	Тайлант үеийн үр дүн	-	1,773,876,711.02	1,773,876,711.02
6	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны	-	2,684,622,751.49	2,684,622,751.49

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	4,213,584,000.00	3,945,404,056.75	(268,179,943.25)	93.6%
Бусад тусгай зориулалтын сангаас	4,213,584,000.00	3,945,404,056.75	(268,179,943.25)	93.6%
Бараа, үйлчилгээний орлого	-	12,500,000.00	12,500,000.00	
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	12,500,000.00	12,500,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,213,584,000.00	3,957,904,056.75	(255,679,943.25)	93.9%
Ажиллагчидтай холбогдсон зардал	349,230,000.00	349,263,159.73	33,159.73	100.0%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	310,000,000.00	309,979,865.29	(20,134.71)	100.0%
Цалин	310,000,000.00	309,979,865.29	(20,134.71)	100.0%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	-	-	-	
Нийгмийн хамгааллын шимтгэл	39,230,000.00	39,283,294.44	53,294.44	100.1%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	33,988,000.00	34,561,868.56	573,868.56	101.7%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,242,000.00	4,721,425.88	(520,574.12)	90.1%
Бараа, үйлчилгээний урсгал зардал	3,494,354,000.00	3,501,923,875.39	7,569,875.39	100.2%
Бусад бараа үйлчилгээний зардал	10,300,000.00	15,753,491.00	5,453,491.00	152.9%
Бичиг хэргийн материал	3,600,000.00	3,590,700.00	(9,300.00)	99.7%
Тээвэр, шатахууны зардал	2,000,000.00	5,129,300.00	3,129,300.00	256.5%
Шуудан холбооны зардал	3,400,000.00	3,614,499.68	214,499.68	106.3%
Дотоод томилолтын зардал	13,300,000.00	11,635,200.00	(1,664,800.00)	87.5%
Банкны үйлчилгээний хураамж	-	179,251.00	179,251.00	
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,408,294,000.00	3,407,161,433.71	(1,132,566.29)	100.0%
Урсгал засварын зардал	-	1,400,000.00	1,400,000.00	
Байрны түрээсийн зардал	53,460,000.00	53,460,000.00	-	100.0%
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	370,000,000.00	366,968,636.00	(3,031,364.00)	99.2%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,213,584,000.00	4,218,155,671.12	4,571,671.12	100.1%
Валютын ханшийн зөрүү		38,387,378.00	38,387,378.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,097,412,931.76		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		875,548,695.39		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн зорилго нь Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлж, бүс нутгийн болон олон улсын эдийн засгийн сүлжээнд холбох гарцыг нээх, хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн боломжийг бүрдүүлэх үйл явц юм.

Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийн эдийн засгийн гол зангилаа, Монгол улс зэргэлдээ далайд гарцгүй CAREC-ийн орнуудыг Ази, Европ болон дэлхийн зах зээлтэй холбодог 4 дүгээр коридорын дагуу стратегийн чухал ач холбогдол бүхий Замын-Үүд чөлөөт бүсэд төвлөрсөн байдлаар хэрэгжүүлнэ.

Төслийн хүрээнд дараах үндсэн 3 бүрэлдэхүүн ажлууд хийгдэнэ. Үүнд:

1. Замын-Үүд чөлөөт бүсэд шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж барих ажлын хүрээнд чөлөөт бүсийн шинж гол зам, явган хүний зам, хог хаягдлыг шилжүүлэх дахин боловсруулах төв, цахилгаан, дулаан, цэвэр усны хангамж, ариутгах татуургын байгууламж бүхий гүний худаг, авто замын аюулгүй байдлын мэдээллийн цогцолбор, ачаа тээвэрлэлтийн автомат рентген болон цахилгаан үүдний төхөөрөмж гэх зэрэг дэд бүтцийн байгууламжуудыг төлөвлөх, хэрэгжүүлэх.
2. Замын-Үүд чөлөөт бүсийн үйл ажиллагаа, менежментийг сайжруулах зорилгоор бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, менежментийн бүтэц, зохион байгуулалтын төсөл боловсруулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх судалгаа гүйцэтгэх.
3. Замын-Үүд болон Эрээн хотын ЭЗХАБ-д зориулан хилийн боомтод нэвтрүүлэх тохиромж зохицуулалт механизм бий болгох, худалдааг дэмжихийн зэрэгцээ боомтын хяналт шалгалт, дижитал тандалт, нүүрний биометрик танилттай сургалтын тээврийн хэрэгслийн шалгах систем, гаалийн автомат мэдээллийн систем, гадаадын гаалийн газрын шалгах системтэй холбогдсон хилийн нэгдсэн менежментийн мэдээллийн санг нэгтгэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төслийн хэрэгжүүлэгч байгууллага нь Эдийн засаг, хөгжлийн яам байсныг Сангийн яамны шийдвэрийн дагуу Шадар сайдын Ажлын алба руу шилжүүлсэн байна. Төслийн удирдах хороо нь төслийн захирал ТХН-ээр дамжуулан АХБ-тай харилцаж, төслийн ерөнхий хэрэгжилтийн явц, зохицуулалт, үр дүнгийн хяналт, үнэлгээг ханган ажиллагаа байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хувь хүнээс оруулсан албан татварын тухай хууль, мөн Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээ, зардал санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

Тайлант хугацаанд төслийн Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ашигладаг “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д өөрчлөлт орсон байна.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд ТХН-ийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,354,923 мянган төгрөгөөр буюу 95.8 хувиар өсжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,097,413.0	875,548.7	(221,864.3)
Дансны ба бусад авлага	84,833.2	84,621.5	(211.7)
Урьдчилж төлсөн зардал	2,970.0	2,970.0	-
Үндсэн хөрөнгө	229,489.2	191,991.8	(37,497.4)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	1,614,496.6	1,614,496.6
Нийт хөрөнгө	1,414,705.4	2,769,628.6	1,354,923.2
Богино хугацаат өр төлбөр	1,352,292.6	85,005.8	(1,267,286.8)
Хуримтлагдсан ашиг	62,412.8	2,684,622.8	2,622,210.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,414,705.4	2,769,628.6	1,354,923.2

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн дансдууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 221,864.3 мянган төгрөгөөр буурсан нь төслийн хүрээнд бий болох мэргэжлийн байгууллагуудад нийлүүлэх хяналтын системийн ажлын төлбөрийг гүйцэтгэлийн дагуу өмнөх оны хуримтлуулсан өр төлбөрийн дүнг барагдуулсантай холбоотой байна.
- Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл 1,614,496.6 мянган төгрөгөөр өссөн нь Замын-Үүд чөлөөт бүсийн дэд бүтцийн ажлын зураг төслийн зөвлөх үйлчилгээний төлбөрийн дүнг хуримтлуулсан дүнгээр бүртгэснээс шалтгаалсан байна.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,267,286.8 мянган төгрөгөөр буурсан нь “Ай Эс Си Эм” ХХК, “Гэрэгэ системс” ХХК, “Аствишн” ХХК-иудын гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна.

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Программ хангамжийн талаарх судалгаа: Төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.0 програмыг ашигладаг. Программ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлагыг хангасан, төсөвт байгууллагад ашиглагдах зөвшөөрөлтэй, гүйлгээг ам.доллар, төгрөгөөр давхар бүртгэх боломжтой, бие даасан серверт болон онлайн хэлбэрээр өдөр бүр архивлаж хадгалдаг. Программ хангамжтай холбоотой хөгжүүлэлт тайлант онд хийгдээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарцуулалтыг 4,213,584.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаад зээлийн эх үүсвэрээс 3,945,404.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,218,155.7 мянган төгрөг буюу 100.1 хувьтай байгаа нь төслийн үйл ажиллагааны төсвийг 4,571.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

	/мянган төгрөгөөр/			
Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Төслийн нэгжийн зардал	435,290.0	443,846.4	(8,556.4)	102.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	3,408,294.0	3,407,340.7	953.3	100.0%
Хөрөнгийн зардал	370,000.0	366,968.6	3,031.4	99.2%
Дүн	4,213,584.0	4,218,155.7	(4,571.7)	100.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу хийгдэх зардлын судалгаанаас тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь унаа, хоолны нэмэгдэл олгоогүй, гадаад албан томилолтын зардал гаргаагүй, орон тооны цомхотгол хийгээгүй, сургалт, семинарыг танхимаар зохион байгуулаагүй, мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаагүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант онд үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх шинжтэй аливаа зардал гаргаагүй бөгөөд төсвийн гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хэрэгжсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

	/мянган төгрөгөөр/		
Хөтөлбөр	Нийт төсөв	Санхүүжсэн дүн	Гүйцэтгэл хувь
Зорилт 1. "Замын-Үүд" чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулах			
ЗҮ-01: Замын-Үүд чөлөөт бүсийн барилгын ажлын нарийвчилсан инженерийн зураг төслийг боловсруулах ажлын үйлчилгээ	2,093,868.2	1,614,496.2	77.1%
ЗҮ-09: Замын-Үүд чөлөөт бүсийн барилгын ажлын хяналт хийх компани	66,545,380.9	137,500.0	0.2%
БА-01: Замын-Үүд чөлөөт бүсийн барилга байгууламж (Багц 1: Гаалийн барилга байгууламж, Тоног төхөөрөмж, Багц 2: Зорчигч тээврийн барилгын байгууламж)			
БА-02: Замын-Үүд чөлөөт бүсээс сумтай холбогдох 2 эгнээтэй 1.2 км замын ажил (тохижилт, явган хүний зам болон тусгаарлах зурвас болон гэрэлтүүлэг)			
БА-06: Замын-Үүд чөлөөт бүсээс БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүстэй холбогдох 4 эгнээтэй 2.1 км замын ажил (тохижилт, явган хүний зам болон тусгаарлах зурвас болон гэрэлтүүлэг)			
БА-03: Газар доорх дэд бүтэц барилга (Багц 1: Дулаан шугам, сувгууд; Багц 2: Бохир усны шугам, Багц 3: Холбоо, цахилгааны шугам, сувгууд)	31,818.2	31,818.20	100.0%
Газар хэмжилтийн төхөөрөмж нийлүүлэх			
Нийт дүн	68,671,067.3	1,783,814.4	2.6%
Зорилт 2. Замын-Үүд чөлөөт бүсийн тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих			
ЗҮ-02: Чөлөөт бүсийн менежментийн зөвлөх үйлчилгээ	4,788,247.4	1,380,348.4	28.8%
ЗҮ-06: Байгаль орчны хяналтын мэргэжилтэн	102,292.1	48,779.8	47.7%
ЗҮ-07: Нийгмийн бодлогын мэргэжилтэн	280,331.9	45,157.6	16.1%
ЗҮ-08: Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	116,054.5	46,389.7	40.0%
Хуулийн зөвлөх	25,643.2	22,793.9	88.9%
Сургалт	2,268,993.9	-	0.0%
Нийт дүн	7,581,563.0	1,543,469.4	20.4%
Зорилт 3. "Замын-Үүд" чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах			
Бизнес болон өгөгдлийн шинжээч	69,377.5	67,699.2	97.6%
Худалдаа хөнгөвчлөл, хилийн удирдлага, мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээний гэрээ	269,857.7	265,385.6	98.3%
ЗҮ-03: Гаалийн нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх	1,447,342.7	1,188,342.3	82.1%
ЗҮ-13: Хилийн нэгдсэн удирдлага модуль өргөтгөлийн хөгжүүлэлт			
ЗҮ-14: Гаалийн автоматжуулсан систем (ГАИС) хилийн удирдлагын нэгдсэн платформ	119,229.0	131,151.9	110.0%
ЗҮ-15: Замын-Үүд чөлөөт бүсийн хяналтын цогц систем			
ҮСХ-05: Гаалийн нэгдсэн мэдээллийн систем (ГИМС) байршуулах тоног төхөөрөмж	443,619.0	260,396.9	58.7%
ҮСХ-06: Хилийн боомт, хяналт бүртгэлийн систем (ХБХСБ) байршуулах тоног төхөөрөмж	350,246.7	354,347.7	101.2%
ЗҮ-20: Хуулийн мэргэжилтэн	81,139.4	24,342.0	30.0%
ЗҮ-21: Мэдээлэл, технологийн мэргэжилтэн	192,706.3	35,397.0	18.4%
Нийт дүн	2,973,518.3	2,327,062.6	78.3%
Бүрэлдэхүүн хэсэг 4. Төслийн удирдлага			

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

ТХН-ийн тавилга	29,775.4	292,170.7	32.2%
ТХН-ийн авто машин	154,545.4		
Тоног төхөөрөмж	133,892.2		
Хуваарилагдаагүй зардал	590,329.3		
АНБ-ны дунд хугацааны хяналтын айлчлал	2,566,576.1	1,766,353.8	68.8%
ТХН-ийн үйл ажиллагаа			
ТХН-ийн 2024 оны санхүүгийн аудит			
Төслийн удирдах хороо (ТУХ)-ны хурлыг зохион байгуулах			
АНБ-ны улирал тутмын тайлангийн уулзалт			
Төслийн 2024 оны үйл ажиллагаанд ЭЗХ-аас хийх хяналт, шинжилгээ			
Нийт дүн	3,475,118.4	2,058,524.5	59.2%
Төслийн нийт хэрэгжилт	82,701,267.0	7,712,870.9	9.3%

Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот тушаалаар гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн зөвлөх үйлчилгээний зардлыг зогсоох шийдвэр гарсантай холбогдуулан төслийн ЗҮ-02, ЗҮ-09, ЗҮ-20, ЗҮ-21 зөвлөх үйлчилгээний ажлуудыг цаашид үргэлжлүүлэхгүйгээр зогсоожээ. Мөн БА-01 ажлыг нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах явцад барилга угсралтын ажлын төсөвт өөрчлөлт орсноос шалтгаалан төслийн хүрэнээс хассан байна.

Бүрэлдэхүүн 1: ЗҮЧБ-ийн барилгын зураг төслийн ажил 77.1 хувийн гүйцэтгэлтэйгээр үргэлжилж байна. БА-02 ажил нь БА-02 болон БА-06 гэж хоёр хэсэгт хуваагдан хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улс, БНХАУ-ын хооронд хилийн холболтын цэгийг тогтоох тохиролцоотой холбоотойгоор уг ажлууд түр хүлээгдэж байна. БА-03 ажлын хүрээнд дулаан, бохир ус, цахилгаан шугам сүлжээний угсралтын ажлууд 2025 оны 4-р улирлаас эхлэн хэрэгжиж эхэлсэн. БА-02, БА-06 болон БА-03 ажлуудын санхүүжилтийг 4-р улиралд олгохоор төлөвлөсөн боловч санхүүжилт олгогдоогүй байна. 2025 оны байдлаар Бүрэлдэхүүн 1 нь 2.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бүрэлдэхүүн 2: Байгаль орчны хамгаалалтын зөвлөхийг 2025 оны 6 дугаар сард сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллуулсан. Зөвлөх нь 2025 оны байгаль орчны хагас жилийн болон улирлын хяналтын тайлангуудыг бэлтгэн АХБ-д хүргүүлсэн бөгөөд тэдгээрийг албан ёсоор хянаж, нийтэд ил болгосон. Нийгэм, жендерийн хөгжлийн зөвлөхийн хүрээнд Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, 2025 оны хагас жил, улирлын тайлангуудыг боловсруулан АХБ-д тайлагнасан. 2025 оны байдлаар Бүрэлдэхүүн 2 нь 20.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бүрэлдэхүүн 3: Гадаадын иргэдийн нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх зөвлөхийн ажил бүрэн хэрэгжиж дууссан. Системийн шаардлага, нарийвчилсан загварчлал, туршилт, сургалт хийгдэж, 2025 оны 1 дүгээр сард гэрээний гүйцэтгэлийг албан ёсоор хаасан. Одоогоор уг систем нь Гадаадын иргэн, харьяатын газрын төв болон салбар нэгжүүд, мөн гадаад дахь Дипломат төлөөлөөгчийн газруудын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

Хилийн цэргийн байгууллагад зориулсан Нэгдсэн хил, гаалийн системийн (IBM) өргөтгөсөн модулийг боловсруулах ажил бүрэн дууссан. Биометр мэдээлэлд суурилсан зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, CAIS системтэй өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлсэн. Системийг Замын-Үүд болон Алтанбулаг чөлөөт бүсэд туршин нэвтрүүлж, хүлээн авалтын актаар баталгаажсан.

Гаалийн ерөнхий газарт зориулсан IBM системийн өргөтгөл болон чөлөөт бүсийн хяналтын системийн хөгжүүлэлтийн ажил амжилттай хэрэгжсэн. Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг бодит цаг хугацаанд солилцох, тайлан статистик гаргах, мэдээлэл экспортлох боломж бүрдсэн. Гэрээний хүрээнд бүх тайлан хүлээн зөвшөөрөгдөж, 2025 оны 1 дүгээр сард ажил бүрэн хаагдсан.

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсүүдийг хамарсан нэгдсэн хяналтын самбар хөгжүүлж, дотоод хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү самбар нь чөлөөт бүсийн аж ахуйн нэгж, зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийг төвлөрсөн байдлаар хянах боломжийг бүрдүүлж, байгууллагууд хоорондын мэдээлэл солилцооны гэрээ байгуулагдсан. Ажил бүрэн дуусаж, гэрээний гүйцэтгэл баталгаажсан.

2025 оны байдлаар Бүрэлдэхүүн 3 нь 78.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бүрэлдэхүүн 4: 2025 онд төслийн хэрэгжүүлэгч байгууллага Эдийн засаг, хөгжлийн яамнаас Шадар сайдын ажлын албанд шилжсэнтэй холбогдуулан зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж, төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчилж, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2025 онд хэд хэдэн удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Өмнөх жилүүдэд үүссэн саатлаас шалтгаалан төслийн гүйцэтгэл удааширсан тул зээлийн хаалтын хугацааг 2028 он хүртэл сунгах саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсний дүнд АХБ-аас зөвшөөрөл авч, зээлийн хаалтын хугацааг 2028 он хүртэл сунгаад байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эдийн загийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх төслийн хүрээнд 2025 онд 3 зорилтын дагуу нийт 76,772,143.2 мянган төгрөгийн төсөвтэй 21 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Төслийн удирдах хорооны 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолоор эдгээрээс 9 худалдан авах ажиллагааг цуцалсан бөгөөд 1 ажиллагаа нь тендерийн үнэлгээний шатанд, 5 нь тендерийн баримт бичиг боловсруулах шатанд тус тус хэрэгжиж байна. Харин үлдсэн 6 худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дуусгасан байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг авч үзэхэд 41,365,774.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь нийт төлөвлөгөөний 53.88 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

/мянган төгрөгөөр/			
Төлөвлөгөө	ХАА-ны төлөв	Төсөв	Гүйцэтгэл
Зорилт 1: "Замын-Үүд" чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулах			
ЗҮ- 09: Замын-Үүд Чөлөөт бүсийн барилгын ажлын гүйцэтгэлийн хяналт хийх компани	Цуцалсан	-	-
БА-01: Замын-Үүд чөлөөт бүсийн гарцын байгууламж болон тусгай тоног төхөөрөмжийн ажил	Цуцалсан	-	-
БА-02: Зам (4 эгнээтэй зам (Х хилийн холбоос) болон 2 эгнээтэй зам, үүнд тохижилт, явган хүний зам болон тусгаарлах зурвас болон гэрэлтүүлэг орно)-ын ажил	Үнэлгээний шатанд	13,289,728.8	-
БА-03: Газар доорх дэд бүтцийн ажил Багц 1: Дулаан цэвэр усны шугам, сүлжээ,	Бүрэн хэрэгжүүлсэн	40,956,668.7	26,500,922.2
БА-03: Газар доорх дэд бүтцийн ажил Багц 2: Ариутгах татуургын шугам сүлжээ			3,018,978.4
БА-03: Газар доорх дэд бүтцийн ажил Багц 3: Холбоо, цахилгааны шугам сүлжээ			11,436,768.1
БА-05: Ландшафт ба цаг уурын өөрчлөлтийн дасан зохицол	Цуцалсан	-	-
ҮСХ-08: Түр барилга (9x18 хэмжээтэй 162 м2 талбайтай орц, гарцын түр барилга)	Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа	389,260.0	-
БА-06: Замын-Үүд чөлөөт бүсээс БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүстэй холбогдох 4 эгнээтэй 2.1 км замын ажил (тохижилт, явган хүний зам, тусгаарлах зурвас болон гэрэлтүүлэг)		21,250,002.4	-
ҮСХ-09: Зорчигчийн ухаалаг гарцын төхөөрөмж (E-Gate) монитор, компьютер, свич, сүлжээний утас, цахилгааны кабель г.м дагалдах хэрэгслийн хамт		306,194.1	-

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

ҮСХ-10: Тээврийн хэрэгслийн ухаалаг гарцын төхөөрөмж. монитор, компьютер, свич, сүлжээний утас, цахилгааны кабель г.м дагалдах хэрэгслийн хамт		25,998.5	-
ҮСХ-11: Зорчигчийн тээшний рентген туяаны хяналтын төхөөрөмж		81,870.0	-
Дүн		76,299,722.5	40,956,668.7
Зорилт 2. Замын-Үүд чөлөөт бүсийн тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих			
ЗҮ-16: ЗҮЧБ-ийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	Цуцалсан	-	-
ЗҮ-17: Замын-Үүд сумын жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан энтрепренершип сургалт зохион байгуулах		-	-
ЗҮ-18: Замын-Үүд сумын иргэдэд ХДХВ/ДОХ, БЗДХ болон ЖСХ-ийн талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах		-	-
ЗҮ-19: Замын-Үүд сумд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа		-	-
ЗҮ-06: Байгаль орчны хамгааллын мэргэжилтэн	Бүрэн хэрэгжүүлсэн	42,136.9	42,136.9
Дүн		42,136.9	42,136.9
Зорилт 3. "Замын-Үүд" чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах			
ТТ-001: Замын-Үүд чөлөөт бүсийн Хилийн автоматжуулсан хяналттай цахим гарц нийлүүлэх	Цуцалсан	-	-
ТТ-002 Замын-Үүд чөлөөт бүсийн Тээврийн хэрэгслийн улсын дугаар танигч бүхий зогсоолын хаалт нийлүүлэх		-	-
ҮСХ-05: Гадаад иргэний мэдээллийн нэгдсэн систем (ГИМНС) байршуулах тоног төхөөрөмж	Бүрэн хэрэгжүүлсэн	216,034.6	177,718.6
ҮСХ-06: Хилийн боомт, хяналт бүртгэлийн систем (ХББХС) байршуулах нэмэлт тоног төхөөрөмж		214,249.2	189,250.0
Дүн		430,283.8	366,968.6
Нийт дүн		76,772,143.2	41,365,774.2
Хэрэгжилт %			53.88%

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төслийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой авлагыг барагдуулах, цалинг үнэн зөв тооцох зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Грант торнтон аудит” ХХК-ийн аудитор Б.Юмжирдулам, туслах аудитор Х.Бямба-эрдэнэ, Д.Ууганбаяр нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер С.Уянга, Чанарын хяналтын партнер Б.Дэлгэрмаа, захирал О.Идшинринжин, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц 2026 онд бүрэн шинэчлэгдэж, Санхүүгийн ажилтан 2026 оны 2 сард томилогдсонтой холбоотойгоор 2025 оны санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,726,101.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,261.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл нь тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой зардлаас бусад үргүй зардал гаргаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөл нь тайлант хугацаанд байршуулах шаардлагатай мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцорсон, 1 мэдээллийг мэдээлэлгүй орхигдуулсан зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээлэл орхигдуулсан зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсөл нь 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайлангаа 1 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх зөвлөмж хүргүүлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны санхүүгийн тайлан завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн төслийн хэрэгжилтийг идэвхжүүлэх зорилгоор 1 албан шаардлага хүргүүлснийг төслийн бүрэлдэхүүн-1 ажлын хүрээнд гүйцэтгэх Замын-Үүд чөлөөт бүс дэх Дулаан болон ус хангамжийн систем, бүрэлдэхүүн-2 ажлын хүрээнд гүйцэтгэх Бохир усны системийн барилга угсралтын ажил, бүрэлдэхүүн-3 ажлын хүрээнд гүйцэтгэх цахилгаан болон холбооны системийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч компаниудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан хамтран ажиллаж эхэлсэн ба гүйцэтгэгч компаниуд 2025 оны 11 дүгээр сараас газар доорх дэд бүтцийн ажлыг эхлүүлсэн хэдий ч гүйцэтгэгч компаниудын хийсэн ажил 22 хувьтай байна.

Хүснэгт 5 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Нийт дүн	1	-	1	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус төсөл нь Замын-Үүд чөлөөт бүс дэх 900 га газарт “Дулаан болон ус хангамжийн систем” ажлыг “S&A” ХХК болон “Prestige Engineering” ХХК 6,750,869.59 ам.доллар, “Бохир усны системийн барилга угсралт” ажлыг “Сайн констракшин” ХХК 757,842 ам.доллар болон “Цахилгаан болон холбооны системийн барилга угсралт” ажлыг “Морин сувд” ХХК 2,913,709.61 ам.доллаароор гүйцэтгэх гэрээг тус тус 2025 онд байгуулсан бөгөөд гүйцэтгэгч компаниуд 2025 оны 11 сараас дэд бүтцийн ажлуудыг төслөөс санхүүжилт авалгүй, өөрийн хөрөнгөөр хийж эхлүүлсэн ба 2026 онд ажлыг бүрэн дуусгах төлөвлөгөөтэй байна.

Иймд дараагийн аудитаар гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа 3 компанийн ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, хөрөнгийн бүртгэл зэрэгт аудитын горим сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,669,552.7 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,669,552.7 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- ЗҮЧБ-ийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулах ажлын хүрээнд Сонголт дизайн ХХК зураг төслийн ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж нийт 1,614,496.5 мянган төгрөг олгосон төлбөрийг хөрөнгөөр хуримтлуулан бүртгэлгүй, шууд зардлаар тайлагнасан.
- Цалингаас суутгасан ХХОАТ-ын өглөг 6,308.8 мянган төгрөгийг буруу ангилан бүртгэсэн, 6,632.6 мянган төгрөгийг журналд бүртгээгүй.
- Үнэлгээний хороонд ажилласан хүмүүсийн урамшуулал 980.4 мянган төгрөгөөс суутган ногдуулах ёстой 98.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг журналд бүртгээгүй.
- Төрийн сангийн валютын харилцах дансны үлдэгдлийг Монгол банкны хаалтын албан ханшаар илэрхийлээгүй, ханшийн тэгшитгэлийн 38,387.4 мянган төгрөгийн олзыг тайлагнаагүй.
- Шатахууны зардал 3,629.3 мянган төгрөгийг томилолтын зардалд буруу ангилан тайлагнасан.

Эдгээр алдаанууд нь Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 21.4-д "Гадаадын зээл болон тусламжаар санхүүжиж буй барилга, байгууламж, их засварын ажлын зардлыг ажил бүрэн дуусаж, ашиглалтад орох хүртэлх хугацаанд дуусаагүй барилга дансанд бүртгэж, санхүүгийн тайлангийн эргэлтийн бус хөрөнгө гэсэн ангилалд толилуулна." гэсэн заалтыг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 2,862,782.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2,459,964.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 402,818.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 2,862,782.7 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 2,835,521.7 мянган төгрөгөөр хэтэрсэн тул "**Хязгаарлалттай**" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1. "Замын-Үүд чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах" ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлын төлбөр 2,360,437.5 мянган төгрөгийг олгохдоо санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгээгүй, зардлаар тайлагнасан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр Хил хамгаалах ерөнхий газар, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Гаалийн ерөнхий газруудад тухайн системүүдийг хүлээлгэн өгсөн байна

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 21.4. Гадаадын зээл болон тусламжаар санхүүжиж буй барилга, байгууламж, их засварын ажлын зардлыг ажил бүрэн дуусаж, ашиглалтад орох хүртэлх хугацаанд дуусаагүй барилга дансанд бүртгэж, санхүүгийн тайлангийн эргэлтийн бус хөрөнгө гэсэн ангилалд бүртгэнэ гэж заасан. Мөн ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын" 1, 2.1-2.5 заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төслийн үйл ажиллагаатай холбогдох тушаал, шийдвэрийг зөрчиж буй үйл ажиллагааг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.1.2. Төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 12,199.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 зөөврийн компьютер, 1 цаас устгагчийг өмнө нь ажиллаж байсан ажилтанд ашиглуулж байсныг буцааж аваагүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, жил бүр элэгдлийн зардал тооцож байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2-т "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах," гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төслийн хөрөнгийг олж авах, зохих ёсоор шийдэх талаар албан шаардлага хүргүүлэв.

5.1.3. Төсөл нь 2023 онд 170,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан "Toyota Staria" маркийн тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаанаас гадуур Төслийн зохицуулагч, Замын Үүд чөлөөт бүсийн захирагчийн алба, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарын хэрэгцээнд ашигласан ба эвдрэл гэмтэл гарснаас засвар үйлчилгээ хийх шаардлага үүссэн байна.

Тайлант онд уг тээврийн хэрэгслийг нийт 12,083 км ашигласан бөгөөд үүнээс 45 хувь буюу 5,432 км нь орон нутагт, 55 хувь буюу 6,651 км нь Улаанбаатар хотод ашиглагдсан байна.

Тээврийн хэрэгслийг зөвхөн төслийн үйл ажиллагаанд бус бусад этгээдүүдэд ашиглуулсан бөгөөд үүнтэй холбоотойгоор хот дотор замд нийт 2,821.1 мянган төгрөгийн дүнтэй шатахууны зардал гаргаж, төслийн зээлийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "6 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд /3.1.2 төсвийн байгууллага, түүний албан тушаалтан/ орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төслийн тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаанаас гадуур бусдад байгууллагуудад ашиглуулж, төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.1.4. Өмнөх оны аудитаар "Жи Ди Пи глобал" ХХК-ийн оршин суугч бус байгууллагын НӨАТ-ын дүн 84,505.8 мянган төгрөгийг суутгаагүй байсныг харилцагч компаниас авах авлагаар бүртгэж, татварын албанд өгөх өглөгөөр залруулсан боловч уг байгууллагад 2025 онд олгосон санхүүжилтийн дүнгээс тухайн татварын авлагыг суутгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Оршин суугч бусын татварын авлагыг холбогдох этгээдээс суутган авч татварын албанд барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.Зөвлөмж

Илрүүлэлт 1. Сангийн сайдын 2024 оны 01/10803 тоот тушаалаар гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн зөвлөх үйлчилгээний зардлыг зогсоох шийдвэр гарснаас хойш "Замын-Үүд чөлөөт бүсийн тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих" ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ажлыг гүйцэтгэсэн “Жи Ди Пи глобал” ХХК-д санхүүжилтийн 389,850.4 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны байгууллагаас гаргасан холбогдох тушаал шийдвэрийг дагаж мөрдөж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

Илрүүлэлт 2. Төслийн тайлант оны үр дүн 975,904.0 мянган төгрөг, ашиглаагүй чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 837,161.0 мянган төгрөг байгаа нь батлагдсан зээлийн эх үүсвэрийг үр дүнгүй ашигласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, зээлийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах.

Илрүүлэлт 3. Тендерийн орлогын 12,500.0 мянган төгрөгийг орлогоор бүртгэхдээ мөнгөн хөрөнгө дансны 31100 гэсэн буруу кодыг ашигласан байна.

Энэ нь 2025 оны Сангийн сайдын А/З-р тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын гуравдугаар хавсралт “Дансны жишиг жагсаалт”-ын 2.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дансны жишиг жагсаалтын дагуу дансны код болон тохируулгыг санхүүгийн системд зөв үүсгэж байх.

Илрүүлэлт 4. Төсөл нь 9 дүгээр сарын цалинг бодохдоо 2 хоногийн чөлөө авсан ажилтны цалингийн зардлыг 468.2 мянган төгрөгийн зөрүүтэй тооцсон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107.1-т “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цалин хөлсийг цагийн бүртгэлд үндэслэн үнэн зөв тооцож, зохих хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ЗҮЧБ-ийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулах ажлын хүрээнд зураг төслийн 1,614,496.5 мянган төгрөгийг биет бус хөрөнгөөр бүртгэлгүй, шууд зардлаар тайлагнасан.	1	1,614,496.5	-	-	1	1,614,496.5	1	1,614,496.5	-	-	-	-
2	Цалингаас суутгасан ХХОАТ-ын өглөг 6,308.8 мянган төгрөгийг буруу ангилан бүртгэсэн, 6,632.6 мянган төгрөгийг журналд бүртгээгүй.	1	12,941.4	-	-	1	12,941.4	1	12,941.4	-	-	-	-
3	Үнэлгээний хороонд ажилласан хүмүүсийн урамшууллын 980.4 мянган төгрөгөөс суутган ногдуулах 98.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг журналд бүртгээгүй.	1	98.1	1	98.1	-	-	1	98.1	-	-	-	-
4	Төрийн сангийн валютын харилцах дансны үлдэгдлийг Монгол банкны хаалтын албан ханшаар илэрхийлээгүй, ханшийн тэгшитгэлийн 38,387.4 мянган төгрөгийн олзыг бүртгээгүй.	1	38,387.4	1	38,387.4	-	-	1	38,387.4	-	-	-	-
5	Шатахууны зардлыг албан томилолтын зардалд буруу ангилан бүртгэсэн.	1	3,629.3	-	-	1	3,629.3	1	3,629.3	-	-	-	-
Дүн		5	1,669,552.7	2	38,485.5	3	1,631,067.2	5	1,669,552.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	"Замын-Үүд чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах" ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлын төлбөр 2,360,437.5 мянган төгрөгийг олгохдоо хөрөнгөөр бүртгээгүй, зардлаар тайлагнасан, ТӨБЗГ-ын шийдвэргүй Хил хамгаалах ерөнхий газар, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Гаалийн ерөнхий газруудад тухайн системүүдийг хүлээлгэн өгсөн.	1	2,360,437.5	-	-	1	2,360,437.5	-	-	-	-	-	-
2	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,199.7 мянган төгрөгийн хөрөнгийг 2021 оноос хойш бусдад ашиглуулж байсныг буцааж аваагүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, жил бүр элэгдлийн зардал тооцож байна.	1	12,199.7	-	-	1	12,199.7	-	-	-	-	-	-
3	2023 онд худалдан авсан "Toyota Staria" маркийн тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаанаас гадуур, Замын Үүд чөлөөт бүсийн захирагчийн алба, Эдийн засаг, хөгжлийн яамны ажилтнууд	1	2,821.1	-	-	1	2,821.1	-	-	-	-	-	-

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ашигласан, үүнтэй холбоотойгоор хот дотор ашиглаж, нийт 2,821.1 мянган төгрөгийн шатахууны зардал гаргаж, төслийн зээлийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан.												
4	“Жи Ди Пи глобал” ХХК-ийн оршин суугч бус байгууллагын НӨАТ-ын 84,505.8 мянган төгрөгийг харилцагч компаниас авах авлагаар бүртгэснийг тайлант онд олгосон дүнгээс татварын авлагыг суутгаагүй.	1	84,505.8	-	-	1	84,505.8	-	-	-	-	-	-
5	Сангийн сайдын 2024 оны 01/10803 тоот тушаалаар гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн зөвлөх үйлчилгээний зардлыг зогсоох шийдвэр гарснаас хойш зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн “Жи Ди Пи глобал” ХХК-ийн санхүүжилтийн 389,850.4 мянган төгрөгийг олгосон.	1	389,850.4	-	-	-	-	1	389,850.4	-	-	-	-
6	Тайлант онд ашиглаагүй чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 837,161.0 мянган төгрөг байгаа нь батлагдсан зээлийн эх үүсвэрийг үр дүнгүй ашигласан байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
7	Тендерийн орлогын 12,500.0 мянган төгрөгийг орлогоор бүртгэхдээ мөнгөн хөрөнгө дансны 31100 гэсэн буруу кодыг ашигласан.	1	12,500.0	-	-	-	-	1	12,500.0	-	-	-	-
8	9 сарын цалинг бодохдоо чөлөө авсан ажилтаны цалингийн зардлыг алдаатай тооцсон.	1	468.2	-	-	-	-	1	468.2	-	-	-	-
Дүн		8	2,862,782.7	-	-	4	2,459,964.1	4	402,818.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хамаарах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, үнэн зөв байршуулсан эсэхийг шалгахад 3 мэдээллийг хугацаа хоцроосон, 1 мэдээллийг байршуулаагүй байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8.9.1 заасны дагуу төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
	Нийт дүн	2	-	-	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1211/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/83/КА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,199,700.15 (арван хоёр сая нэг зуун ерэн есөн мянга долоон зуун төгрөг арван таван мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй 2 зөөврийн компьютер, 1 цаас устгагч нийт 3 хөрөнгийг тус төсөл хэрэгжиж эхэлсэн 2021 онд Шадар сайдын ажлын албанд ажиллаж байсан албан тушаалтнууд болох зөвлөх 2, шинжээч 1 ажилтнууд хүлээн авч ашигласан боловч төслийн өмчид буцаан шилжүүлээгүй байна. Төслөөс уг хөрөнгүүдийг буцаан авах талаар удаа дараа албан бичиг, и-мэйл хүргүүлсэн хэдий ч тайлант хугацааны эцэст хүртэл шийдэгдээгүй, үндсэн хөрөнгийн бүртгэлд хэвээр байна. Мөн дээрх хөрөнгүүдийн элэгдлийн зардлыг үргэлжлүүлэн тооцож бүртгэж байна.

Энэ нь УСНББОУС-16 Үндсэн хөрөнгийн стандартын 7 дугаар зүйл. “Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: (а) тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж тухайн аж ахуйн нэгжид орох магадлалтай; (б) хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах.”; 55 дугаар зүйл. Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс, өөрөөр хэлбэл удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил, нөхцөл байдалд уг хөрөнгийг авчирсан үеэс эхлэн элэгдүүлнэ.”, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын эзэмшилд бодитоор байхгүй байгаа 3 ширхэг үндсэн хөрөнгө нь үндсэн хөрөнгийн бүртгэлд хэвээр байгаа, хөрөнгүүдийн элэгдлийн зардлыг жил бүр тооцож байгаа зөрчлийг арилгаж, хөрөнгийг буцаан авч биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн зохицуулагч Ц.Мөнхдэлгэр, захирал З.Болдбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ОЙДШИНРИНЖИН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1212/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026 /83/КА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төслийн 3 дахь бүрэлдэхүүн "Замын Үүд чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах" ажлын хүрээнд "Аствишн" ХХК болон "Гэрэгэ систем" ХХК-удтай 2024 онд 2,360,437,483.90 (хоёр тэрбум гурван зуун жаран сая дөрвөн зуун гучин долоон мянга дөрвөн зуун наян гурав төгрөг ерэн мөнгө) төгрөгийн гэрээ байгуулж хамтран ажилласан байна. Гэрээний дагуу гүйцэтгэгч компаниудад олгосон төлбөрийг санхүүгийн тайланд хөрөнгөөр хуримтлуулан бүртгээгүй, зардлаар тайлагнан бүртгэсэн.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандаж тогтоол шийдвэр гаргуулаагүй байхад тайлант онд Хил хамгаалах ерөнхий газар, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Гаалийн ерөнхий газруудад нэвтрэх системийг хүлээлгэн өгч акт үйлдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3.3-д "Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн хүрээнд бий болсон нэвтрэх системийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийг гаргуулаагүй, ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн зохицуулагч Ц.Мөнхдэлгэр, захирал З.Болдбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.ИДШИНРИНЖИН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1213/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/83/НА-СТА-ТХМ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл нь 2023 онд 170,000,000.00 (нэг зуун далан сая) төгрөгөөр худалдан авсан Toyota Staria маркийн тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаанаас гадуур Төслийн зохицуулагч, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн албанд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарын хэрэгцээнд ашигласан ба эвдрэл гэмтэл гарснаас засвар үйлчилгээ хийх шаардлага үүссэн байна. Тайлант онд уг тээврийн хэрэгслийг нийт 12,083 км ашигласан бөгөөд үүнээс 45 хувь буюу 5,432 км нь орон нутагт, 55 хувь буюу 6,651 км нь Улаанбаатар хотод ашиглагдсан байна.


Тээврийн хэрэгслийг зөвхөн төслийн үйл ажиллагаанд бус бусад этгээдүүдэд ашиглуулсан бөгөөд үүнтэй холбоотойгоор хот дотор ашиглаж, нийт 2,821,115.00 (хоёр сая найман зуун хорин нэгэн мянга нэг зуун арван тав) төгрөгийн шатахууны зардал гаргаж, төслийн зээлийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд /3.1.2 төсвийн байгууллага, түүний албан тушаалтан/ орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаанаас гадуур бусад байгууллагад ашиглуулж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн зохицуулагч Ц.Мөнхдэлгэр, захирал З.Болдбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  А.ЦОГБАЯР
ИДШИНРИНЖИН

9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1214/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/83/НА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар залруулсан “Жи Ди Пи глобал” ХХК-иас суутгах оршин суугч бус байгууллагын НӨАТ-ын дүн 84,505,826.00 (наян дөрвөн мянга таван зуун таван мянга найман зуун хорин зургаан) төгрөгийг тайлант онд олгосон дүнгээс суутган аваагүй, авлага үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Жи Ди Пи глобал” ХХК-иас татварын авлагыг суутгаж аваагүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн зохицуулагч Ц.Мөнхдэлгэр, захирал З.Болдбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦОГБАЯР

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ийн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Б.ИДШИНРИНЖИН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAГ-49.Docx

1526181886